МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 29 өдөр Дугаар 56 Улаанбаатар хот

## Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын их засварын ажлын жагсаалтын Харьяа байгууллагуудын их засвар /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээний Эрүүл мэндийн хөгжлийн төвийн барилгын өргөтгөл, их засварын 290.000.000 / Хоёр зуун ерэн сая/ төгрөгийн гэрээ байгуулах, гэрээ сунгах, цуцлах эрхийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга / Ч.Бат-Эрдэнэ /-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ОЮУНБААТАР

080185

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 11 сарын 16 өдрийн
451 дугаар тушаалын хавсралт

## УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЛБАРТ 2016 ОНД ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ЖАГСААЛТ

/төгрөг/

| № | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | 2016 онд санхүүжих дүн |
|---|---|---|---|---|---|
| | | Эхлэх | Дуусах | | |
| | ИХ ЗАСВАР | | | 5,430,600,000 | 5,430,600,000 |
| | Харьяа байгууллага | | | 3,859,019,270 | 3,859,019,270 |
| 1 | Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн их засвар /Улаанбаатар, Баянгол/ | 2016 | 2016 | 318,000,000 | 318,000,000 |
| 2 | Хавдар судлалын үндэсний төв, Энэтхэгийн ЗГ-ийн буцалтгүй тусламжтай холбоотой хийгдэх засвар /Улаанбаатар, Баянзүрх/ | 2016 | 2016 | 65,000,000 | 65,000,000 |
| 3 | Хавдар судлалын үндэсний төвийн их засвар тохижилт /Улаанбаатар, Баянзүрх/ | 2016 | 2016 | 263,528,270 | 263,528,270 |
| 4 | Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Сантехник болон гадна зогсоолын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар/ | 2016 | 2016 | 1,350,000,000 | 1,350,000,000 |
| 5 | Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зөвлөх поликликийн Барилгын засвар /Улаанбаатар, Баянгол/ | 2016 | 2016 | 260,000,000 | 260,000,000 |
| 6 | Эрүүл мэндийн хөгжлийн төвийн барилгын өргөтгөл, их засвар /Улаанбаатар, Сүхбаатар/ | 2016 | 2016 | 290,000,000 | 290,000,000 |
| 7 | Хүүхдийн төв сувилалын их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ | 2016 | 2016 | 484,916,000 | 484,916,000 |
| 8 | Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн дулааны шугам, дээврийн төмөр солих, гадна фасадны засвар /Улаанбаатар, Баянзүрх/ | 2016 | 2016 | 111,250,000 | 111,250,000 |
| 9 | Гэмтэл согог судлалын үндэсний төвийн их засвар /Улаанбаатар, Баянгол/ | 2016 | 2016 | 200,000,000 | 200,000,000 |
| 10 | Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Мэс заслын тасгийн гадна хүзүүвчийг битүүлж вакум шилэн ханатай болгох засвар/Улаанбаатар, Баянзүрх/ | 2016 | 2016 | 12,000,000 | 12,000,000 |

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 10 сарын 05 өдөр Дугаар 393 Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 заалт, Засгийн газрын 2015 оны 02 дугаар сарын 02 ны өдрийн 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2015 оны Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны Худалдан авах ажиллагааны газарт хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг хавсралтаар батлсугай.

2. Хавсралтаар баталсан ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу зохион байгуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга / Г.Ганчимэг /-д үүрэг болгосугай.

САЙД Г.ШИЙЛЭГДАМБА

031410

Эрүүл мэнд, Спортын сайдын
2015 оны 10 сарын 09 өдрийн
393 дугаар тушаалын хавсралт

## УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ 2015 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ЖАГСААЛТ

/сая.төг/

| № | Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр, хүчин чадал, байршил | Хэрэгжүүлэх хугацаа | Батлагдсан Төсөвт өртөг | 2015 онд санхүүжсэн |
|---|---|---|---|---|
| | **1.1 Яамны харьяа эрүүл мэндийн байгууллагуудын их засвар** | | **2,966,700,000** | **1,483,300,000** |
| 1 | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн барилгын цахилгааны их засвар | 2015-2016 | 520,000,000 | 275,000,000 |
| 2 | Халдварт өвчин судлалын үндэсний төвийн сантехникийн засвар | 2015-2016 | 730,000,000 | 231,400,000 |
| 3 | Эрүүл мэнд, спортын яамны дээвэр болон гадна зогсоолын засвар | 2015-2016 | 150,000,000 | - |
| 4 | Эрүүл мэнд,спортын яамны байрны их засвар | 2015-2016 | 490,000,000 | 400,000,000 |
| 5 | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн их засвар | 2015-2016 | 252,000,000 | 200,000,000 |
| 6 | Хүүхдийн төв сувиллын халаалт, халуун усны гадна шугамын засвар | 2015-2016 | 48,000,000 | 27,600,000 |
| 7 | Гэнэтийн хүчин зүйлийн дагуу хийгдэх засвар | 2015-2016 | 211,600,000 | 105,800,000 |
| 8 | Улсын гуравдугаар төв эмнэлгийн дээврийн засвар | 2015-2016 | 350,000,000 | 243,500,000 |
| 9 | Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дээврийн засвар, узель засвар | 2015-2016 | 41,000,000 | |
| 10 | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн барилгын засвар | 2015-2016 | 102,100,000 | |
| 11 | Гэмтэл согог судлалын үндэсний төвийн хаалганы засвар | 2015-2016 | 10,000,000 | |
| 12 | Гэмтэл согог судлалын үндэсний төвийн хүлээн авах яаралтай тусламжийн байрны засвар | 2015-2016 | 62,000,000 | |